

СЕКСИЗМ БА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ДҮР

Ч. Чойсамба*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор, дэд профессор

Түлхүүр үг: сексизм, эмэгтэйчүүдийн эсрэг сэжиг бодол, жендерийн стереотип, хэвлэл мэдээллийн хэрэгслээр имиж бүрдүүлэх нь.

Сексизм гэхээр юуны түрүүнд секстэй, өөрөөр хэлбэл, бэлгийн харьцаатай холбоотой зүйл толгойд бууна. Тэгвэл сексизм хэмээх нэр томьёо *sex* буюу хүйс гэсэн үгээс гаралтай бөгөөд хүмүүсийг хүйсийн харьяаллаас нь үүдэн ялгаварлан гадуурхах үзэл суртал ба үйл ажиллагааг заадаг юм. Сексизм ихэнхдээ эм хүйсийг ялгаварлан гадуурхах хэлбэрээр тохиолддог бөгөөд тухайн хүйсийн ямар нэг тодорхой чанарыг үгүйсгэдэг, эсвэл ямар нэг чанарыг тулгадаг үзэл, номлол дээр тулгуурладаг¹.

Тухайлбал: улиг болсон, улиг болсон учир аксиом мэтээр олон нийт хүлээн авдаг «Эмэгтэй хүний гээг урт, ухаан богино» гэдэг хэллэг бол сексизмын нэг илрэл юм. Учир нь эмэгтэй хүн төрөлхийн ухаан муутай гэсэн санааг агуулдаг. Энэ бол эмэгтэйчүүдийн тодорхой нэг чанарыг бүрэн үгүйсгэж буй хэрэг мөн. Эл хэллэгийг цааш дэлгэрүүлж, ургуулан бодвол нэгэнт эмэгтэй хүн ухаан муутай учир эрэгтэй хүн төрөлхийн ухаантай байх ёстой гэсэн санаа гарч ирнэ. Энэ бол тодорхой нэг хүйст тодорхой нэг чанарыг «нааж», тулгаж байгаа учир мөн л сексизм болно.

Манай уран сайхны кинон дээр амьдралын хашир туршлагатай гэмээр нэгэн өвгөн нэг залууд: «Авгай гэдэг чинь ав, авсны дараа гай гэж байгаа юм» хэмээн хоёр дээр нэмэх хоёр, тэнцүү дөрөв гэж хэлж байгаа мэт хэв нэг тайлбарласан нь яагаад ч юм ой тоонд хадагдаж, нээрээ ч тийм юм билүү гэсэн ойлголт төрүүлснийг нуух юун. Үнэхээр л, киноны нэр нь мартагдаж, харин тэрхүү үг санаанд үлджээ. Тэгэхээр эмэгтэй хүн эр хүнд гай л болдог, ямар ч тус нэмэргүй гэсэн, даян дэлхийн социализмаас илүү худал «онол»-ыг тэр кино сурталчилснаараа сексист кино болсон байна. Тэгвэл эхнэртэй эрчүүд гоонь эрчүүдийг бодвол хэдэн насаар удаан амьдардгийг юу гэж үзэх вэ?

Сексизм хэмээх нэр томьёо 1960-аад оны үед АНУ-д Эмэгтэйчүүдийн чөлөөлөх хөдөлгөөний үеэр үүсчээ. Энэхүү нэр томьёо эмэгтэйчүүдийн эсрэг сэжиг бодол, жендерийн стереотип буюу хэвшмэл загварыг хэлэлцэх үеэр илүүтэй хэрэглэгддэг.

Нэгэнт эмэгтэйчүүдийн эсрэг сэжиг бодол, жендерийн стереотип гэсэн нэр томьёо гарч ирсэн болохоор эдгээрийг тайлбарлах нь зүйтэй болов уу.

Эмэгтэйчүүдийн эсрэг сэжиг бодол бол асуудлын мөн чанарт нэвтрэлгүй эмэгтэй хүнд бурууг тохох явдал юм². Энэ нь маш олон хэлбэрээр илэрдэг. Тухайлбал:

хүчирхийлэлд автсан эмэгтэй хүнд заавал ямар нэг буруу тохдог. Эмэгтэй хүнийг эхэлж өдсөн, сээтэн хаясан, аальгүйтсэн, үгүй гэхэд нимгэн, эсвэл биеэ барьсан хувцас өмссөн учир эрэгтэй хүнд хүчиндүүлсэн гэх сэжиг бодол дэндүү газар авчээ. Хэрэв нэг эмэгтэйг нөхөр нь зодсон гэж сонсвол өөрөөс нь л болсон байлгүй гэж бид хүлээж авдаг. Хэдийгээр «байлгүй» гэж таамаглаж байгаа ч мөн л бурууг эмэгтэй хүнд буюу хохирогчид ухамсартай, ухамсаргүй тохож байгаа. Мөн ажил төрөл нэг л урагшгүй байгаа эр хүн үүний бурууг эхнэртээ, эмэгтэй хүнд тохих тохиолдол ч цөөнгүй байдаг. Энэ бол мөн л эмэгтэйчүүдийн эсрэг сэжиг бодлын илрэл юм.

Жендерийн стереотип бол эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд биеэ яаж авч явдаг тухай хүмүүсийн

хоорондын харилцааны явцад үүссэн ерөнхий төсөөлөл, ойлголт юм³. Энэхүү ойлголт, төсөөлөл нь бодит үнэнд нийцэхгүй ч байж болдог. Агуу философич Платон хүртэл: «Мөн чанарынхаа хувьд эмэгтэй хүн эрэгтэй хүний адил бүхий л ажилд оролцож болно, гэхдээ эмэгтэй хүн бүх тал дээр эрэгтэйгээсээ сул дорой байна»⁴ гэсэн байдаг. Үе үеийн суут сэтгэгчдийн бүтээлийг задлан шилжилбэл: эмэгтэй хүн асуудалд зөнгөөрөө ханддаг бол эрэгтэй хүн логикийн үүднээс ханддаг аж⁵. Мөн эр хүн идэвхтэй, тогтвортой чанарыг илтгэдэг бол эмэгтэй хүн сул үлбэгэр чанар,

сэтгэлийн хөдөлгөөн, хувирамтгай аашийг илэрхийлдэг байна. Эдгээрийг нэгтгэн дүгнэхэд, эмэгтэй хүний жендерийн стереотип гарч ирнэ. Тодорхой нөхцөл байдалд эмэгтэй хүн сэтгэл хөдлөлдөө дийлдэж, тогтворгүй зан гаргаж, улмаар алдаж эндэх нь түгээмэл гэгддэг аж.

Тэр ч байтугай реклам дахь дүрийн асуудлыг судалсан эрдэмтэд эмэгтэй хүн бол гай барцад, зовлон зүдгүүрийн эх булаг, эрэгтэй хүн бол гай барцад, зовлон зүдгүүрээс хам-

гаалагч, эмэгтэй хүн ихэнхдээ худал ярьдаг, улмаар түүний сурталчилж буй бараанд итгэж болохгүй, эрэгтэй хүн үнэнч, шударга, тиймээс түүний сурталчилж буй барааны чанарт итгэж болно гэсэн хэвшмэл стереотип байдгийг тогтоожээ⁶.

Сексизм

олон шинжээрээ хүнийг арьс-

ны өнгөөр нь ялгаварлан гадуурхдаг расизмыг санагдуулдаг. Расизм хар арьстнуудыг оюуны болон биеийн хөгжлийн хувьд сул дорой байх тавилантай, тэд байгалиас ингэж заяагдсан бөгөөд хэзээ ч цагаан арьстнаас илүү сэтгэж, бүтээж чадахгүй гэж номлодог. Тэр ч байтугай хар арьстнууд европ, америк хүний адил бусдыг хайрлаж, өрөвдөж, догдолж, шаналж, баярлаж, жаргаж чаддаггүй гэдэг. Сонирхолтой нь расистууд өөрсдийн энэхүү номлолоо баримтаар нотлох оролдлогыг хэзээ ч хийж байгаагүй ажээ.

Тэгвэл сексизм эмэгтэй хүн оюуны болон биеийн хөгжлөөрөө

«

Реклам дахь дүрийн асуудлыг судалсан эрдэмтэд эмэгтэй хүн бол гай барцад, зовлон зүдгүүрийн эх булаг, эрэгтэй хүн бол гай барцад, зовлон зүдгүүрээс хамгаалагч, эмэгтэй хүн ихэнхдээ худал ярьдаг, улмаар түүний сурталчилж буй бараанд итгээж болохгүй, эрэгтэй хүн үнэнч, шударга, тиймээс түүний сурталчилж буй барааны чанарт итгээж болно гэсэн хэвшмэл стереотип байдгийг тогтоожээ.

»

ямагт эрэгтэй хүнээс дорд байх тавилантай гэж номлодог бөгөөд расизмын адил үүнийгээ баталдаггүй. Сексизмын зарим номлолоос тоочвол: эмэгтэй хүн сэтгэн бодох чадвар муу, сэтгэлийн хэт хөдлөлтэй, юманд бодитой хандах чадваргүй учир улс орныг удирдаж чадахгүй, нийгэмд тэдний гүйцэтгэх үүрэг бага, тэд аливаа юмыг хутган үймүүлж байдаг гэх аж.

Сексизм үзэл суртлын хувьд хэзээ үүссэнийг тааж хэлэхэд бэрх. Гэхдээ түүхийн гүн рүү орвол сексизмын үр хөврөл эртний сонгодог зохиолуудад ажиглагддаг. Тухайлбал: соёлт хүн бүрийн мэдэх Гомерийн «Илиада» хэмээх хүн төрөлхтний мөнхийн бүтээлд 11 жил үргэлжилж, үй олон хүний амь насыг авч одсон Тройн дайн Елена гэдэг гоо бүсгүйгээс үүдсэн гэжээ. Үлгэр домгийг аваад үзвэл атаа жөтөө, хорон санаа, хов живийн бурхад нь дандаа эм хүйстэй байдаг⁷. Энэ бүхэн нь эмэгтэй хүн бол хов зөөдөг, хутган үймүүлдэг, хар буруу санаатай гэсэн жендерийн стереотип үүсэхэд зохих нөлөөгөө үзүүлжээ.

Тэгвэл балар эртний үеийн энэхүү хэвшмэл загвар одоо байна уу? Сонирхолтой нь байсаар байна. Цаашид ч байх төлөвтэй. Яагаад? Үүний гол бурууг манай ХМХ тодорхой хэмжээгээр үүрнэ. Яагаад гэвэл эмэгтэй хүнийг хүнийх нь хувьд доромжилсон, тэднийг дорд үзсэн номлол, үзэл ардчиллын хоточ нохой байх ёстой манай ХМХ-ээс салахаа больжээ.

Хэвлэл мэдээлэлд эмэгтэйчүүдийг ямар өнцгөөс тусгаж байна гэдэг нь сонирхолтой сэдэв юм. Ингээд нэр бүхий хэвлэлийн нийтлэлийг утга агуулгын хувьд задлан шилжлэхэд дараах ерөнхий дүр зураг бууж байна.

Эмэгтэйчүүдийг хормой султай гэж бичих нь энгийн үзэгдэл болжээ. Тэгэхдээ тэдэнтэй нэр холбогддог

эрчүүдэд бурууг огт тохохгүй байна. Амрагийн холбооны гол буруутан нь эмэгтэй хүн болдог. Уг нь гэр бүлээс гадуурх бэлгийн харьцаа үүсч байгаад эмэгтэй хүн, эрэгтэй хүн адилхан л хариуцлага хүлээмээр. Иймэрхүү мэдээлэл ихэнхдээ хов живэн дээр тулгуурласан гэдгийг хэлэх хэрэггүй биз. Тухайлбал, «Дуучин Э.Минжинсорын ээлжит амраг тодров», «Поп Сараагийн шинэ амрагаар "Нисванис"-ын Амгаа тодорлоо», «Энэ жил загвар өмсөгч Одгэрэл олон эртэй холбогдож хамгийн секс хүүхнээр тодорсон бол дуучин Сэрчмаа...», «Сэрчмаа минь "хормойгоо битгий сул тавиарай!», «Сэрчмаа юу, Сэрэлмаа юу?», «Минжинсор аягүй "дуртай хүүхэн"» г. м. Иймэрхүү гарчгийг хязгааргүй үргэлжлүүлж болно гэдэгтэй та бүхэн надтай санал нийлэх болов уу. Эдгээр «мэдээлэл»-д шинэ, ээлжит, удаах зэрэг үг орсныг анхаарах хэрэгтэй. Үүгээрээ сэтгүүлч нэр дурдагдсан эмэгтэйчүүдийг хормой султай гэж нотлох гээд байгаа юм. Ингэхэд нэг асуулт байна. Эрэгтэй хүнийг амрагаа солилоо гэсэн нийтлэл манай хэвлэлд хэр олон үзэгддэг вэ?

Зарим сэтгүүлч ярилцлага авахдаа сексийн холбогдолтой ганц-нэг асуулт тавьчихаад түүнийгээ гарчигт өгдөг практик дэлгэрчихээд байна. Хальт харсан уншигчид энэ нь нилэнхүйдээ секс ярилцлага мэт сэтгэгдэл төрүүлж болох юм. Жишээ татъя.

«Аттила» баарны тайчигч Г.Туяа: «Сексийн сайхныг юутай ч зүйрлэхгүй, хамгийн гоё, гайхамшигтай зүйл».

Яруу найрагч Р.Эмүжин: «Сексийг эрэгтэй, эмэгтэй хүнтэй ямар ч хэлбэрээр, яаж ч хийж болдог».

Т. Саран: «Надтай секс хийнэ гээд чадал нь хүрэх юм бол "пожалуйста"».

Загвар өмсөгч Л. Эрдэнэсүвд:
«Миний сэрэл хөхөндөө байдаг.
Сексийн хувьд гоё "унтдаг" хүнтэй
таараагүй явна».

Эмэгтэй хүнийг илэрхий
доромжилсон өнгө аястай нийтлэл
манай хэвлэлд цөөнгүй үзэгддэг.
«Хамгийн азгүй Загвар өмсөгч
Хосцэцэг яаж ч хичээгээд
амжилтанд хүрдэггүй», «Топ модель
Э.Одгэрэл тун азгүй», «Минжээ
өөрөө өөртөө үерхлийн захиа бичдэг
байжээ», «Сэрчмаа эрчүүд рүү
өөрөө залгаад байдаг», «Мисс
Ё.Нямжав "шалдаа" буужээ»,
«Загвар өмсөгч Ихэрцэцэг
хадмынхаа хаалгыг "маажиг"
сууна», «С.Оюун хүүхэд
төрүүлэхээсээ өнгөрсөн» г. м.
Эдгээр гарчгийг уншихад нэр
дурдагдсан эмэгтэйчүүдийг ингэж
бичиж буйдаа бах нь ханасан,
тавласан өнгө аяс илт мэдрэгдэж
байна.

Өвөөдөө хүчиндүүлсэн дөрвөн
охины тухай мэдээлэхдээ
сэтгүүлч «Монголд гарсан
хамгийн "сексуальный" гэмт хэрэг»
гэж гарчиглажээ. 12-14 насны
дөрвөн охин бүх насаараа хохирсон
байхад "сексуальный" гэж
тодотгосон нь юу гэсэн үг вэ? Тэрхүү
хүчингийн хэргийн тухай «Хамгийн
гайхалтай нь мань өвөө их л
сексуальный хүчинддэг байжээ. /.../ 4
ач охинтойгоо хөзөр тоглоод
хожигдсон нь хожсоноо үүрнэ шүү
хэмээн мунагладаг байв. /.../ Ингээд
сексуальный мунаг өвөөтэй хийсэн
бяцхан ярилцлагаа толилуулж
байна» гэх зэргээр бичсэн байна.
Мань сэтгүүлч ийм хэрэг гарсанд
ихэд олзуурхсан бололтой.

Хүний зарим нэг чанарыг,
ихэнхдээ сул талыг зөвхөн
эмэгтэйчүүдэд л байдаг чанар
мэтээр бичих нь элбэг юм. Энэ нь
бидний дээр ярьсан эмэгтэйчүүдийн
эсрэг сэжиг бодол, жендерийн
стереотиптэй шууд холбоотой.

Жишээ сонирхье. «Дуучид бүсгүй
хүний атаархуу зангаар янхантай
өрсөлдсөн нь нэг их буруу биш».

Эмэгтэйчүүдийн авьяас
чадварыг үгүйсгэх нь түгээмэл
болжээ. «Хөгшин хятадын хүүхдийг
гаргахыг хүссэнгүй» нийтлэлд
дуучин С.Сэрчмааг «Хятад ший
янгуунд дуулж байвал таарах
дуучин» гэж «тодорхойлжээ». Цааш
нь «"Эрх саран" тоглолтон дээр
гонжролдсон урт халаад шиг юм
өмсөөд тайзан дээгүүр навсагнаж
байсан... Түүнийг ... эмээ стильд
дуртай гэж рок попынхон хоорондоо
шивнэлддэг...» гэх зэргээр дайрч
давшилжээ. Мөн зарим нэг
нийтлэлийн гарчгийг дурдахад л
хангалттай болов уу. «Том хөх,
бөгсөөрөө нэрд гарсан Номин уран
бүтээлч биш ээ», «Эрос Ариунаа яг
л Нарантуул захын наймаачин шиг»,
«Б.Түмэнхүслэн тэргүүтэй найрааны
цуврал миссүүд "Монголын сайхан
бүсгүйн" алтан эрдэнийн титмийн
үнэ хүндийг унагаж байна», «Сараа
хөхөөрөө даллаад ч бут авч
чадсангүй», «Төрийн шагналт
Н.Сувд чадлаараа УГЖ болсон уу» г.
м. Гоц авьяастан Өнөрчимэгийг:
«Гар нь байсаар байтал хөлөөрөө
зурж өвчигнөдөг Өнөрчимэг гэж нэг
хүүхэн байдгийг мэдэхгүй хүн үгүй
биз. Ямар ч шаардлага хэрэгцээ үгүй
атал усан дор зурж "мэдрэлтдэг" энэ
хүүхнийг...» мэтээр доромжилсон
мөрүүдийг уншиж байхад: «Арай ч
дээ!» гэж халаглах багадаж байна.

Эмэгтэйчүүдийн авьяас
чадварыг нь үгүйсгэхийн зэрэгцээ
мэдлэг боловсролыг үл тоомсорлох
явдал бол газар авсан үзэгдэл.
Манай нэгэн үеийн эмэгтэйчүүдийн
хамгийн боловсролтой бүсгүйн нэг
Х.Хуланг «УИХ-ын эмэгтэй
гишүүдийнхээ дунд хамгийн хөөрхөн,
эгдүүтэй, бас хөөрхөд (эх дээрээ
алдаатай) нь Хулан гишүүн зүй
ёсоор тооцогддог билээ» гэжээ. Энэ
бол эмэгтэйчүүдийн мэдлэг

боловсролыг үл тоомсорлож буйн илрэл юм. Эмэгтэй хүн гэхээр ухаан богино, гэзэг урт гэгчээр мэдлэг боловсрол чухал биш, харин нөхөрт тоогдохын тулд царай зүс сайтай байх хэрэгтэй гэсэн лалын ертөнцийн номлол энд мэдрэгдэж байна гэлтэй.

Эмэгтэй хүн муу муухай бүхний эхлэл гэсэн санаа манай хэвлэлд цухалзаж л байна. «Дуучин Минжинсор Өгий нуурыг бузартуулж нутгийн олны хараалыг барж байна» мэдээнд дуучин Э.Минжинсор «Нүцгэн байхыг минь битгий хараарай» дууны клипээ хийлгэхдээ Өгий нуурын усанд орсон тухай «Энэ өвөл тус суманд зуд турхан болж нэлээдгүй хэмжээний мал хорогдсон байна» гэж бичжээ. Юутай ч өнтэй өвөл болж өнгөрсөн бол Э.Минжинсорыг магтаж бичихгүй байсан нь тодорхой. Тэгээд ч үнэхээр Э.Минжинсор усанд орсноос болж зуд болсныг хэн тогтоогоод, хэн гэрчилсэн юм? «Өмнөговь аймгийн Булган суманд чөтгөрт хүчиндүүлсэн бүсгүй жирэмсэн болжээ» «мэдээ»-нд сэтгүүлч зохиосон зүйлээ үнэмшилтэй болгох зорилгоор «Ер нь хар хүч гэж ч эм хүнд их шүглэсэн байдаг. /.../ Яагаад гэвэл тэрээр амьдралыг буй болгодог савыг биендээ агуулж буй. /.../ Буддын шашинд /.../ эм хүнийг шулмын язгууртай, аливаа хорлолын үндэс гэж үздэг» гэх зэргээр мэдэмхийрчээ.

Чөлөөт хэвлэлийн салшгүй нэг хэсэг бол чөтгөр шулмын тухай хүүрнэл юм. Эдгээрийг сонирхвол: «Дөрвөн замын шулмас усны гудамжинд амьдарч байсан Лянхуа гэдэг бүсгүй гэнэ», «Алтны хайгуулынхны залуу, шалдан шулмаснаас болж солиорох шахжээ», «Эцэг нь чөтгөр болсон охиндоо эргэж шүглэсэн тохиолдол» г. м. Ер нь чөтгөр шуламтай нийтлэлийг тооны хувьд задлан шинжлэхэд 2/3 тохиолдолд шулмын тухай өгүүлсэн байдаг. Тэр

эмэгтэй муу хүн байгаад л шулам болсон хэрэг гэж үзвэл мөн л хүйсийн асуудал ямар нэг байдлаар сөхөгдөнө. Ер нь чөтгөр мөрөөрөө, харин шулам хүн амьтан айлгаж ичээсэн байх нь олонтаа. Эсвэл эмэгтэй хүн чөтгөрт хүчиндүүлээд хүүхэд төрүүлж, хүн төрөлхтнийг аюулд учруулж буй тухай өгүүлнэ. Сонин хэвлэлийн нийтлэлээр бол манай Монголын хүн ам дотор чөтгөрийн хэд хэдэн хүүхэд байгаа бололтой. Зарим нь бүр 2-3 ой хүрчихсэн байлтай. Хүн амын тооллого хийхэд тэдгээрийг хүн гэж үздэг юм бол уу, аль эсвэл хүний тооноос хасдаг юм бол уу? Бүү мэд. Зарим нэгэнд энэ нь инээдтэй санагдаж болно. Харин миний хувьд эмэгтэй хүний мөн чанарыг, тодруулбал нөхөн үржихүйн чадварыг илт гутаан доромжилсон бусармаг үйлдэл юм. Эмэгтэйчүүд хүн төрөлхтний үр удмыг үргэлжлүүлэх ёстой байхад чөтгөртэй хурьцаад, чөтгөрийн зулзагыг төрүүлээд явж байна гээд бодохоор... ийм зүйл бичиж байгаа сэтгүүлчдэд хэлэх ч үг олдохгүй нь.

Манай хэвлэлд «сонины нугас»-ыг наалдан падаар наачихсан гэлтэй. Хэвлэлийн нийт материалын бараг тэн хагас нь зохиомол зүйл байдаг. Дан зохиомол материалаас бүрдсэн «үндэсний чөлөөт хэвлэл» ч байна. Иймэрхүү нийтлэлд эсвэл садар самуун, эсвэл гэмт хэргийн тухай өгүүлсэн байдаг. Мэдээж, эдгээр нийтлэлд гол буруутан нь эмэгтэй хүн байдаг. Туршлагатай сэтгүүлч «сонины нугас»-ыг шууд л таньдаг. Учир нь потенциал доогуур сэтгүүлч зохиож бичихдээ логикийн болон бусад алдааг заавал гаргасан байдаг. Худал хэлсэн хүн баригддаг шиг худал бичсэн сэтгүүлч уншигчдыг хуурч чадахгүй. «Дөнгөж төрүүлсэн үрээ хөнөөсөн оюутан бүсгүй», «Төрсөн үрээ хуйхалж хороосон эх», «Лесби хүүхнүүд нэгнийхээ аминд

хүрсэн нь», «Эр нөхрөө согтуудаа хутгалан алжээ» г. м. нийтлэлийг уншаад үзэхэд худал болох нь илэрхий. Ер нь л Монголын нийгмийн гэмт хэргийн ертөнцөд эмэгтэйчүүд «ноёрхож» байгаа гэлтэй. Олон жил нөхөртөө зодуулаад цөхрөнгөө барсан эмэгтэй нөхрийнхөө аминд хүрсэн хэргийн тухай бичихдээ манай хэвлэл бараг л гэр бүлээр нь хүйс тэмтэрдэг аюумшигт алуурчны хэргээс илүүтэйгээр дуулиан дэгдээж байх жишээтэй. Садар самуунтай холбоотой хэдэн нийтлэлийг үзье.

Энд гарчгийг нь дурдахад хангалттай болов уу. «Нансалмаа хүүхнийг том хэрэглэлтэй Чалхаадорж эрхтэнээрээ өргөж гайхамшигийг үзүүлжээ» (эх дээрээ алдаатай), «Архангайн "хавчаар" Бямбацэцэг шиг хүүхэн одоо тун ховордсон» г. м.

Ер нь худал мэдээлэлд үнэхээр хязгаар алга. Тодруулж хэлбэл, эмэгтэйчүүдийг доромжилж зохиоход сэтгүүлчийн фантазид хязгаар алга. Ийм нэг гарчгийг уншихад юу бодогдох вэ? «Эхнэр нь хар хэрээ болон хувирч, цонхоор нисэн оджээ.» Заавал яагаад эхнэр нь гэж? Энэ нийтлэлд шуламтай гэр бүл болсон Самдан гэх залуугийн тухай өгүүлнэ. Түүний шулам-эхнэр Гэрэлт-Наран яаж хар хэрээ болсон тухай ингэж бичжээ. «Гэрэлт-Наран ламыг харуут арагш зумран ухарч, улмаар элэг эмтрэм муухай чарлан унаснаа гэв гэнэт ухасхийн босож, толгойгоо хоёр гараараа базлан өвдөг сөхрөн суувай. Ламтан нас

барсан хүнд уншдаг ерөөл номыг ам хамхилгүй уншихад хүүхэн ам хамар нь татвалзан, гар хөл нь чичирснээ эцсийн удаа муухай чарлан, царай нь зэвхийрч, үс нь арзайгаад, амь тавин үхэдхийн унав. "Шамбалын ерөөл"-ийг чанга унших тусам бие махбодь нь хөдөлгөөнгүй цогцос мэт хөшсөнөө гэв гэнэт хар хэрээ болох нь еэ бүү үзэгд гэмээр аймшигтай байлаа. Нөгөө үзэсгэлэнт хүүхэн хар хэрээ болонгуутаа нэлмэгэр бараан далавчаа дэлгэн, налмалзтал дэвж, байшингийн адар таазыг пад

падхийн алгадан нисмэглэснээ "Самдаан би танд хайртай. Гэвч салъя гэж салсангүй, салаа замын эрхээр саллаа. Сайн сууж, сайхан амьдраарай. Би чамд муу юм нэгийг ч үлдээхгүй. Ээ, гэгээн тэнгэр минь зовлонгоосоо хагацаж, зовсон сүнс зовлого биеэ

«

Ер нь л Монголын нийгмийн гэмт хэргийн ертөнцөд эмэгтэйчүүд «ноёрхож» байгаа гэлтэй. Олон жил нөхөртөө зодуулаад цөхрөнгөө барсан эмэгтэй нөхрийнхөө аминд хүрсэн хэргийн тухай бичихдээ манай хэвлэл бараг л гэр бүлээр нь хүйс тэмтэрдэг аюумшигт алуурчны хэргээс илүүтэйгээр дуулиан дэгдээж байх жишээтэй.

»

амраая. Гуаг гуаг" гээд цонхны гэгээвчийн зүг салх татуулан нисэв. Цонхны шилийг хэд хэд хүчтэй мөргөж, саарьтай сарвуугаараа самардан, эвэр хошуугаараа тоншилсоор тасхийтэл хагалж, хашаанд нисэн гарав...»

«Талийгаач эхнэр нь 49 хоног дээрээ шулам болж ирээд хүүхдүүдээ авч оджээ» гэсэн гарчгийг уншихад хэдийгээр «сонины нугас» болох нь илэрхий ч нэг л цэрвэмээр. Эл нийтлэлд 2001 оны 8-р сард Булган аймгаас хот руу нүүж ирсэн Доржсүрэнгийх гэдэг айлын тухай өгүүлнэ. Хашаа барих газар олдоогүйн улмаас тэднийх «...Даландавхарын манаачийн баруун талын

шарилтай арваадхан метрийн зай-
тай гэрээ барьжээ». Цагаан сарын
шинийн нэгний өглөө Доржсүрэн
«хоёр том хүүгийнхээ хамтаар чулуу
овоолж байгаад их гал бадраан
сунаж мөргөж баахан сүржигнэжээ».
Гэвч тэр шөнө Доржсүрэнд гавлынх
нь ухархайнаас хөх гал улалзсан
араг яс үзэгдэж, «Чи миний болоод
бүг чөтгөр цуглардаг газрыг бузар-
ласан. Тиймээс нөхөд маань зугтаж
одсон. Одоо би ганцаараа болсон.
Тиймээс гэрийнхнийг чинь авч
чамайг ганцаар үлдээнэ» гэж
заналхийлжээ. Маргааш орой нь
«эхнэр нь гэнэтхэн савж унаад л цус
харвачихсан аж». Талийгаачийн 49
хоногийн шөнө Доржсүрэнг «унтаж
байтал хөнжлөөс нь хэн нэгэн
татахад давхийн сэржээ. Гэтэл
мөнөөх арга яс, шүд нь ярзайсан
зэвхий царайтай үхдэлийн хамт
зогсож байгаа нь сарны гэрэлд тод
харагджээ. Араг яс дув дуугүй
зогсоно. Харин сэгсгэр үстэй үхдэл
хаичн зэвүүнээр "Би шимнусын
төрлийг олсон. Одоо хүүхдүүдээ нэг
сайхан ертөнц рүү аваачихыг хүсч
байна. өгөр толгой чи мөддөө
үхэхгүй. Амьдаараа чөтгөр болж
бидний араас ирэх болно" гэж
хэлээд зэвүүнээр харахад нүднээс
нь хөх гал сүүмэлзэн харагджээ.»
Хэсэг хугацааны дараа Доржсүрэн
«гэртээ согтуу очиход дөрвөн үр нь
угартаад нас барчихсан байжээ».
Эл «нугас»-ны товч агуулга бол энэ.
Үүнийг уншиж байхад арай ч дээ,
үүнийг эрээчсэн сэтгүүлч эхээс төр-
сөн баймаар, тэгсэн атлаа эх хүнийг
ингэж муухай ой ухаанд багтам-
гүйгээр доромжилж яаж чадаж
байнаа гэж дуу алдмаар байлаа.

Энэ бүхнийг нэгтгэн дүгнэхэд
өнөөгийн Монголын ХМХ дэх
эмэгтэйчүүдийн ерөнхий дүр төрх
бууж байна. Эр нөхөр нь гэр бүлээ
тэжээх гэж чадан ядан зүтгэж байхад
эхнэрүүд нь завхайрч, архидаж,
садарлаж, гэмт хэрэг үйлдэж, хов

жив зөөж, хутган үймүүлж явна
Яагаад гэвэл тэд төрөлхийн ухаан
муутай, шулмын язгууртай. Тэд
авьяас чадваргүй, ямар нэг амжил-
тад хүрсэн бол хөх, бөгс, царай
зүснийхээ сайнд ингэж яваа, тэд их
зантай, боловсролгүй атлаа их юм
бодож байдаг. Тэд гэртээ л хүүхдээ
хараад, тогоо шанага тачигнуулаад
сууж байх заяатан. Монголын эмэг-
тэйчүүдийг ийм л өнцгөөс харуулж
байгаа нь гашуун үнэн юм.

Бидний судалгааны өөр нэг тал
бол эмэгтэй улс төрчдийн имижийг
ХМХ-ээр хэрхэн илэрхийлсэн бай-
дал байлаа.

Судлаач хүн бол яллагч биш.
Тэр тусмаа өмгөөлөгч биш.
Тиймээс энэхүү судалгааг
хийхдээ миний бие аль нэг ХМХ-ийг
яллах, хэн нэг хүнийг өмгөөлөх
зорилго урдаа тавьсангүй. Гагцхүү
бодит дүр зургийг, үнэн үгийг
хүргэхийг урьдал болголоо.

Бид судалгааны эх хэрэглэг-
дэхүүн болгож «Сэрүүлэг» сонины
2004 оны 1-16 дугаар, «Ноцтой
мэдээ» сонины 2004 оны 1-24
дугаар, «Маш нууц» сонины 2004
оны 1-28 дугаарт нийтлэгдсэн эмэг-
тэй улс төрчдийн тухай материалыг
ашигласан болно. Түүнчлэн судал-
гааны зорилгоос хамааран зарим
хэвлэлийн нийтлэлд түшиглэсэн юм.

Юуны түрүүнд эмэгтэйчүүдийн
асуудлыг манай хэвлэлүүд тун ч
хангалтгүй тусгадаг болох нь
харагдлаа. Ганц жишээ дурдахад
«Ноцтой мэдээ» сонины 2004 оны
эхний 24 дугаарт ердөө 10 бодит
мэдээ, материал нийтлэгдсэн байна.
Ер нь «Ноцтой мэдээ» гэлтгүй,
эмэгтэйчүүдийн тулгамдсан асууд-
луудыг хөндсөн дорвитой нийтлэ-
лийг сонины хуудаснаас эрээд эрээд
олдохооргүй болжээ.

Улс төрийн сэдэвтэй мэдээ,
материалыг «Сэрүүлэг» сонин «Пар-
ламентын тогоонд» буландаа, «Маш
нууц» сонин «Бид далд мэдээллийг

ил болгоно» уриатай «Politics news. Domestic» буландаа нийтэлдэг ажээ. «Сэрүүлэг» сонины энэ оны эхний 16 дугаарын «Парламентын тогтоонд» буланд нийт 139 мэдээ нийтлэгдсэний 12 нь буюу 8,6% нь эмэгтэй улс төрчдийн тухай байна. Харин «Маш нууц» сонины хувьд «Politics news. Domestic» буланд энэ оны эхний 25 дугаарт 124 мэдээ хэвлэгдсэний 16 нь буюу ердөө 12,9% нь эмэгтэй улс төрчдийн тухай мэдээ байна. Үүнээс үүдээд манай тогтмол хэвлэлүүд эмэгтэй улс төрчдийн тухай асуудалд төдийлөн ач холбогдол өгдөггүй гэж дүгнэж болох нь.

Хэвлэл мэдээлэлд эмэгтэй улс төрчдийг ямар өнцгөөс тусгаж байна гэдэг нь сонирхолтой асуудал юм. Ингээд нэр бүхий хэвлэлийн нийтлэлийг утга агуулгын хувьд задлан шилжлэхэд дараах ерөнхий дүр зураг бууж байна.

Нийт мэдээ, материалын 21,4 хувьд эмэгтэй улс төрчдийг эерэг талаас нь, 7,1 хувьд нь төвийг сахисан талаас, харин 71,5 хувьд нь сөрөг талаас нь харуулжээ (хүснэгт №1). Чухам ямар шалгуураар эерэг, төвийг сахисан, сөрөг гэсэн үнэлгээ өгсөн бэ гэвэл хэрэв мэдээнд баатрын үйлдэл, үйл ажиллагаа, хэлсэн үг, хийсэн ажил зэрэгт эерэг үнэлгээ өгсөн, сайшаасан бол бид үүнийг эерэг имиж гэж үзсэн болно. Харин ямар нэг үнэлгээ өгөөгүй, цэвэр мэдээллийн шинжтэй бол төвийг сахисан, хэрэв шүүмжлэх, гүтгэх, доромжлох зэргээр дайрч давшилсан бол тухайн улс төрчийн талаар сөрөг имижийг бүтээсэн мэдээ гэж үзсэн юм.

Нийт мэдээ, материалын 71,5 хувьд эмэгтэй улс төрчдийг сөрөг талаас нь тусгасан гэсэн баримт яах аргагүй сэтгэл түгшээж буй юм.

Судалгаанд хамрагдсан материалд нийт 14 эмэгтэй улс төрчийн тухай өгүүлсэн байна. Аль ч талаас

нь аваад үзсэн үнэхээр чамлалттай тоо юм. Монголын хүн амын талаас илүү, нийт сонгогчдын мөн адил талаас илүү хувийг эзэлдэг эмэгтэйчүүдийг ердөө 14 төлөөлөгч ХМХ-үүдэд төлөөлж байна гэдэг бол бодох ёстой асуудал юм. Эдгээрээс зургааг нь буюу 43 хувийг эерэг талаас нь, хоёрыг нь буюу 29 хувийг төвийг сахисан талаас, есийг нь буюу 71 хувийг сөрөг талаас нь тусгасан байна (давхардсан тоогоор).

Зохиомлоор бий болгосон хуурамч имиж удаан насгүй нь хэн хүнд ойлгомжтой. 2000-2004 оны парламентад сонгогдсон эмэгтэй улс төрчдийг нилэнхүйд нь тохиолдлын гишүүд, үл бүтэх хүмүүс гэсэн санаа манай ХМХ-үүдээс ханхалж байна.

Эмэгтэй улс төрчдийн тухай өгүүлэхэд С.Оюуны имижийн тухай тогтож ярих нь зүйтэй юм. Ер нь С.Оюун эмэгтэй улс төрчдөөс хэвлэлийн хуудаснаа хамгийн их өгүүлэгдсэнээс (18 удаа) үзэхэд гол нь юзмейкер гэлтэй. Нийт мэдээ, материалын 34 хувьд нь С.Оюуны тухай өгүүлжээ. Гэхдээ дандаа сөрөг талаас нь. Ганцхан мэдээ төвийг сахисан байсан нь УИХ-ын сонгуульд «Эх орон-Ардчилал» эвсэл ялалт байгуулбал Гадаад хэргийн сайдаар томилогдож магадгүй гэсэн мэдээлэл байв.

Ялангуяа «Маш нууц» сонин УИХ-ын гишүүн С.Оюуны эсрэг зохион байгуулалттай хэвлэлийн дайн дэгдээсэн гэж үзэх бүрэн үндэстэй. Энэ он гараад С.Оюуныг үндэслэл, баримтгүй гүтгэж гүжирдсэн мэдээ, материал бараг дугаар алгасалгүй гарч байсан юм. Үгээр хүнийг алж болдог гэдэг. Хэрэв энэ үг үнэхээр үнэн юм бол С.Оюуныг манай чөлөөт гэгддэг хэвлэл нэг бус удаа зольбин үгээр намнажээ. Ер нь «Маш нууц» сониныг уншиж байхад нэг л хүний бичлэгийн өнгө аяс мэдрэгдэж байсан юм.

Энэ бүхэн яаж дууссан нь сонирхолтой. «Маш нууц» сонины 21 дүгээрт «Уншигчдын анхааралд» гэсэн гарчигтай залруулга нийтлэгдсэн байна. Үүнийг сийрүүлбээс: «Манай сонины хэд хэдэн дугаарт УИХ-ын дэд дарга, хатагтай С.Оюунтай холбоотой материалууд нийтлэгдэж байсан билээ. Тухайн үедээ уг нийтлэлүүдийг баталгаажуулалгүйгээр нийтэлж байсан нь алдаа болсон байна. Тиймээс УИХ-ын дэд дарга С.Оюун болон түүний гэр бүлээс уучлалт хүсье. "Маш нууц" сонины редакц» гэх аж.

Судлаач хүний хувиар анхаарал татсан нэг зүйлийг дурдмаар санагдлаа. Тус сонины эхний 16 дугаарт С.Оюуны тухай 8 мэдээ, материал нийтлэгдсэн бөгөөд «хатагтай» гэсэн үг ердөө ганц удаа тохиолдсон юм. Тэгээд ч тэр үгийг ёжилсон маягаар хэрэглэсэн байсан. Харин залруулгадаа «хатагтай» гэж оруулсныг анзааралгүй өнгөрөхийн аргагүй байв.

Цаг бусаар нас барсан ах, мөн эр нөхөр, өвчтэй хүүхэдтэй нь холбож хэлэх хэлэхгүй үгээр хүнийг доромжилчихоод, УИХ-ын дэд дарга болонгуут нь уучлалт гуйдаг бол орчин үеийн манай нэгэн үеийн сэтгүүлчдийн гэм биш, зан, цаашлаад нэрийн хуудас гэлтэй.

Илэрхий гүтгэн дайрсан, эсвэл тэнгэрт тултал магтсан мэдээ, материалыг уншиж байхад захиалсан эзэнтэй байх гэсэн бодол төрж байсныг нуух юун. Үнэндээ Д.Оюунхорол, С.Оюун нарыг шүүмжилсэн, О.Цолмон, Б.Ундармаа нарыг магтсан зэргийг уншихад танд ч ийм бодол төрөх байх. Гутаан доромжилсон агуулгатай зарим мэдээ, материалыг өрсөлдөгчөө доош хийхийн тулд эмэгтэйчүүд эрх гэж ярьдаг эмэгтэйчүүд өөрсдөө захиалан бичүүлж байдаг нь харамсалтай.

Асуудал дэвшүүлсэн, задлан шинжилсэн өгүүлэл, нийтлэл

байтугай ийм үнэр ч судалгаанд хамрагдсан материалд алга. Мөн эмэгтэй улс төрчдийн тухай хөрөг найруулал судалгааны эх хэрэглэгдэхүүн болсон сонинуудын нийт 68 дугаарт нэг ч тохиолдсонгүй. Ер нь ч байдаггүй бололтой.

Энэ бүхнийг нуршсаны эцэст эмэгтэй улс төрчдийн түгээмэл дүр төрхийг гаргахыг хичээсэн юм. ХМХ дэх Монголын эмэгтэй улс төрч ямаршуухан зан чанартай хүн бэ? Үнэндээ чадварлаг, мэдлэгтэй, боловсролтой, ард түмнийхээ итгэлийг даасан, туршлагатай улс төрч гэж хэнийг ч онцолсонгүй. Нилэнхүйд нь хараар буджээ. Тэгэх тэгэхдээ ямар ч үндэслэлгүй дайрч давшилсан, галдан шүүмжилсэн, гүжир үгээр гүтгэсэн нь хэрээс хэтэрчээ.

Монголын дундаж эмэгтэй улс төрчийг сонины хуудаснаас харья гэвэл:

- хувийн амьдрал нь замбараагүй, гэр бүлийн хувьд тогтворгүй, бусдын гэр бүлийг үймүүлж, айлын хүүхдийг өнчрүүлсэн, эр нөхөр нь эсвэл архичин болдог, эсвэл өөр хүүхэн рүү зугатдаг;

- улс төрийн ямар ч мэдлэг, чадваргүй боловч намын фоноор УИХ-ын гишүүн болсон, гэхдээ сөрөг хүчнийхэнд хов зөөж явдаг, намаа муулдаг, тэднийг хэн ч таньдаггүй, УИХ-д суухдаа хийсэн ажил байтугай, хэлсэн үг ч байхгүй, УИХ-ын хэлгүй «Каролия»-нуудын нэг;

- алдар нэр, албан тушаалын дон шүглэсэн, хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхийн тулд яахаас ч буцахгүй;

- өнгө мөнгөний хойноос улайран хөөцөлддөг;

- хятад цустай;

- намбандаа таараагүй;

- увайгүй ааштай, эмэгтэй хүний мяндсан ухаантай;

■ нас барсан дотныхоо хүний нэрийг барьж, УИХ-д сонгогдчихоод юу ч хийдэггүй.

Эмэгтэй улс төрчдийн тухай ийм ойлголтыг ХМХ-үүд дөрвөн жилийн турш уншигчдын толгой руу чихэж байхад энэ зуны сонгуулиар парламентад урьд өмнө байгаагүй цөөн тооны эмэгтэй сонгогдсон нь арга ч үгүй биз. Хэн ийм хүмүүсийн төлөө саналаа өгөх юм?

Гэхдээ эдгээр сөрөг имиж хэр үнэний хувьтай, хэр үндэслэлтэй вэ? Үүнийг бид эрүүл ухаанаар тунгаан бодож, дэнслэн үзэх ёстой. Аль эсвэл эмэгтэй хүн парламентад сонгогдож, ард түмэн, улс орныхоо төлөө зүтгэх эрхгүй гэж үү? Улс орны хөгжилд эмэгтэй улс төрчдийн оруулж буй хувь нэмрийг үндсээр нь үгүйсгэх бол энгийнээр хэлэхэд манай сэтгүүлчид, ХМХ-үүдийн гаргаж буй туйлын бүдүүлэг алдаа юм.

Эмэгтэй улс төрч, сонгогчдын хооронд ХМХ-үүд төмөр хөшиг татсан гэж хэлж болно. Яг л хүйтэн дайны үеийнх шиг. Энэ хөшигнөөс болж, сэтгүүлчдийн тарьсан утаат манан дундаас эмэгтэй улс төрчдийн жинхэнэ нүүр царай, чадал чадавхи огт харагдахгүй байна.

Бид асуудалд бодитой хандах ёстой. Өнөөдрийн Монголын нийгмийг бүхэлд нь, тэрхүү нийгмийн хамгийн бичил нэгж болох гэр бүлийг эмэгтэй хүн үүрч, авч явж байна. Тэд нийгмийн хөгжилд өөрсдийн зохих хувь нэмрээ оруулсаар, нийгмийг

хөгжүүлсээр, нийгмийн төлөө зүтгэсээр явна. Зарим талаар тэд эрчүүдээс илүү ачааг үүрч, тэднээс илүү хариуцлага хүлээж, тэднээс илүү ихийг бүтээж байна. Тэгвэл ХМХ дэх эмэгтэйчүүдийн дүр тэдний бодит амьдрал дахь дүртэй хэр тохирч байна вэ? Үүнийг бодолцох цаг болжээ. Бодолцоод ч зогсохгүй, үзэл бодол, үйл ажиллагаандаа өөрчлөлт оруулах цаг болжээ.

Эмэгтэй хүн амьдралын гэрэл гэгээ, сайн сайхны билэг тэмдэг гээд хэлчихвэл надтай санал зөрөх хүн

гарахгүй болов уу. Гэтэл архи ууж, хүний алтан аминд хүрэхээс сийхгүй болчихсон, нас барсан хойноо ч шулам болж бусдыг айлгаж ичээх тийм эмэгтэйчүүд намайг тойрч буй мэт сэтгэгдэл сонин хэвлэл уншихад төрж буйг хэлэх хэрэгтэй.

Ер нь эмэгтэй хүний гэгээлэг, сайн

хан дүрийг тэр бүр сониноос хайгаад олохгүй болсон нь орчин үеийн Монголын сэтгүүл зүйн нэг эмгэнэл билээ.

Ишлэл

¹ 2002. Словарь гендерных терминов. М. С. 200-201.

² Там же. С. 181.

³ Там же. С. 62-65.

⁴ Ишлэлийг: там же. С. 62.

⁵ Булгаков С. Н. 1996. Тихие думы. М.: Флоренский П. А. Имена // Тайна имени. Т. 1. Харьков. 1995.; Розанов В. В. Религия и культура // Собр. соч. Т. 1. М. 1995.; Логинов А. А. Женщина и мужчина. 1989. Красноярск нарын бүтээлийг үзнэ үү.

2004. Рекламный образ. Мужчина и женщина. М. С. 97
1998. Мифология. Большой энциклопедический словарь. М. 4-е изд. бүтээлийг үзнэ үү.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- 1 А ж г и х и н а Н. И. 2001. Гендерные стереотипы в масс-медиа. //Женщины и СМИ: свобода слова и свобода творчества. М.
- 2 Б а д е н т э р Э. 1995. Мужская сущность. М.
- 3 Б е р д я е в Н. А. 1990. Философия неравенства. М.
- 4 Б о в у а р С. 1997. Второй пол. СПб.
- 5 Б у л г а к о в С. Н. 1996. Тихие думы. М.
- 6 Л о г и н о в А. А. 1989. Женщина и мужчина. Красноярск.

- 7 1998. Мифология. Большой энциклопедический словарь. М. 4-е изд.
- 8 2004. Рекламный образ. Мужчина и женщина. М.
- 9 Р о з а н о в В. В. 1995. Религия и культура //Собр. соч. Т. 1. М.
- 10 2002. Словарь гендерных терминов. М.
- 11 Ф л о р е н с к и й П. А. 1995. Имена //Тайна имени. Т. 1. Харьков.
- 12 Steinem Gloria. 1999. Revolution from within. N.-Y.

Резюме

В данной статье автор рассматривает проблемы гендерного аспекта в современной монгольской печати. При этом автор уделяет главное внимание атрибутам формирования имиджа женщин-политиков и гендерным стереотипам в печати. Автор опирался на богатый фактологический материал.

Хүснэгт №1

Улс төрч эмэгтэйчүүдийн имижийг тогтмолд хэвлэлд гаргасан байдал

№	Нэр	Албан тушаал (тухайн үед)	Эерэг		Төв		Сөрөг		Нийт тоо
			Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	
1	Оюунгэрэл	УИХ-ын Төв аймгийн 36-р тойрогт бие даан нэр дэвшигч	-	-	-	-	1	100	1
2	Д.Оюунхорол	УИХ-ын гишүүн	-	-	-	-	1	100	1
3	Тунгалаг	АЗХ	-	-	-	-	-	-	1
4	Б.Ундармаа	НИТХ-ын СХД-ийн 27-р тойрогт бие даан нэр дэвшигч	1	100	-	-	-	-	1
5	Д.Алтай	УИХ-ын гишүүн	-	-	-	-	2	100	2
6	Р.Нарангэрэл	УИХ-ын гишүүн	-	-	-	-	2	100	1
7	Б.Туяа	УИХ-ын гишүүн	1	33	2	66	-	-	3
8	Б.Арвин	УИХ-ын гишүүн	3	75	-	-	1	25	4
9	Н.Болормаа	УИХ-ын гишүүн	-	-	-	-	4	100	4
10	Т.Ганди	УИХ-ын гишүүн, ЭМ-ийн сайд	2	50	1	25	1	25	4
11	Б.Дэлгэрмаа	УИХ-ын гишүүн, ЭМ-ийн сайд	1	25	-	-	3	75	4
12	Х.Хулан	УИХ-д нэр дэвшигч	-	-	-	-	4	100	4
13	О.Цолмон	УИХ-д нэр дэвшигч	-	-	-	-	-	-	4
14	Б.Долгор	Ерөнхий сайд Н.Энхбаярын гэргий, «Ерөөл» сангийн тэргүүн	4	100	-	-	-	-	4
15	С.Оюун	УИХ-ын гишүүн	-	-	-	-	6	100	6
		УИХ-ын гишүүн, УИХ-ын дэд дарга	-	-	1	5	17	95	18
			12	21,4	4	7,1	40	71,5	56

**Улс төрч эмэгтэйчүүдийн имижийг тогтмол хэвлэлүүд
үгээр илэрхийлсэн байдал**

№	Нэр	Имижийг үгээр илэрхийлсэн байдал
1	Оюунгэрэл	Сөрөг: Молиго үмхүүлэв; Эвгүй байдалд орсон нэр дэвшигч (НМ:16).
2	Д.Оюунхорол	Сөрөг: Хувьсгалт намынханы дотроо ярьсан яриаг сөрөг хүчний хэвлэлд задалж, хов зөөгөөд байдаг; «Тагнуул»-ын хэргийн эзнээр тодорсон; Д.Оюунхорол гишүүнд бүгд илт дүйгүйцэх болсон аж; Улс төрийн ноён нуруугүй; Нэр төрд дуртай; Хувийн ашиг сонирхолоо гүйцэлдүүлэхийн тулд намаа ч худалдахад бэлэн нөхөр; Намынхан дундаа ямар ч нэр хүндгүй болсон; Улс төрийн тайзнаас холдож байгаа; Улс төрч болоогүй, улс төрийн шалгуур даваагүй; УИХ-д гарч ирсэн санаандгүй гишүүдийн нэг; Хувийн нь замбараагүй амьдралын талаар хэвлэлээр маш их зүйл бичигдэж түүнийг баллах шахсан бөгөөд МАХН-ын нэр хүнд л энэ эмэгтэйд ялалт байгуулахад нөлөөлсөн; Амин хувийн ашиг сонирхолоо гүйцэлдүүлэхийн тулд хэнтэй ч нэр холбогдоход бэлэн; Хэд хэдэн нөхрийн өвөр дамжсан; Хүүхэд өнчрүүлж, хүний нөхрийг булааж суудаг замбараагүй амьдралтай хүүхэн; УИХ-ын гишүүн болоод байхдаа айл гэр үймүүлж өөрөөсөө олон дүү хүний толгой эргүүлж авч суусан гэдэг; Өмнө нь тэрээр бас л хүүхэд өнчрүүлж, хүний нөхөр булааж суусан; Оюунхоролын тарыг таньсан нөхөр нь сэтгэлээр унаж архинд орж, сүүлдээ бүр түүнээс салахын түүс болохдоо өөрөөсөө олон эгч ахимаг настай хүүхэн дагаад талийж өгсөн; Намын удирдлагаа сэм муу хэлж явдаг (С:13).
3	Тунгалаг	Сөрөг: Дэлхийн Ардчилсан залуучуудын хуралд оролцох урилгыг ... хуйвалдан авсан; Гэнэт од болсон шигээ огцом гологдох болсон; М.Энхсайханы нэр хүндийг унагасан (МА:28).
4	Б.Ундармаа	Зөрөг: Удирдахуйн ухаанд боловсорсон; Өндөр чадавхитай; Тойргийн сонгогчид Б.Ундармаагийн мөрийн хөтөлбөрийг онцгойлон үзэж, дэмжиж байна (МН:25).
5	Д.Алтай	Сөрөг: УИХ-д тохиолдлоор сонгогдсон (МН:3, 16); Хэн ч танихгүй гишүүн (МН:3); Дөрвөн жил шахам хугацаанд ганц ч үг дуугараагүй хэлгүй «Каролия»-нуудын нэг (МН:3, 16); Сонгогчиддоо хийсэн ажлаа тайлагнасан нь олны элэг доог болоход хүргэжээ (МН:3); Уул нь гэмгүй эмэгтэй гэнэ (МН:16); Тойргоосоо зугатсан «зовж» яваа нэгэн (МН:16).
6	Р.Нарангэрэл	УИХ-ын эмэгтэй гишүүдийн нэг гоо сайхандаа төдийлөн анхаардаггүй (Х98:16);

7	Т.Ганди Ёстой архаг тамхичин гэнэ. Тэрбээр ... өдөрт нэг хайрцгийг, бусдыг дайлсан үедээ хоёр хайрцгийг өлхөн татчихдаг ажээ. «Ээ бурхан гомчигсум, эмэгтэй хүн гэдэгт нь ч эргэлзмээр» гэж зарим нөхөд нь тамхи татхыг нь хорихын тулд дамшигладаг гэнэ (Х98:16); Орос хэлний багш эмэгтэй (С9.25-26); Найз хүүхнүүд нь Нарая тэгж байгаад ёстой зайтай амьтан ... хэмээн шүүрс алдан ярьцгаасан байна (С9.25-26); Мань хүн ч арай л эрт эмээ болчихлоо гээд сэтгэл дундуурхан байна лээ гэхчилэн бөөн бөөн юм ярьцгаажээ (С9.25-26). Эерэг: УИХ-д дараалан сонгогдсон туршлагатай парламентач (С:30); Эрүүл мэндийн салбарыг хөнгөхөн аваад явчихна гэж олон хүн итгэл хүлээлгэж байгаа (С:30); Эмэгтэй улстөрчдийг төдийлөн хүлээн зөвшөөрөхийг хүсдэггүй эрчүүд түүнд буулт хийсэн (С:30); Тахир дутуу иргэдийн дунд олон ажил зохион байгуулсан (НМ:14); МТДИБУХ-ны ерөнхийлөгчөөр ажиллах хугацаандаа ... нэлээд их ажил хийж гүйцэтгэжээ (НМ:14). Төв: Хоолны хордлого авч... (ХуА2002:34). Сөрөг: ...Нөхрөөсөө тусдаа амьдраад удаж байгаа... (ШС00: 2).
7	Б.Туяа Эерэг: Завханд ч Эрдэнэтэд ч алзахгүй гараад ирнэ гэж үнэлэх нь бий; Төв: Сонгуулиар 600 мянган төгрөгний үнэтэй, хүр хорхойн шүлсээр нэхэгдсэн дээлээр гангарсан (С:21).
8	Д.Арвин Эерэг: Хэнтий аймгийн иргэд УИХ-ын гишүүн Д.Арвингийн тойрогтоо хийж буй ажил үйлст сэтгэл хангалуун байгаа (НМ:11); Хэнтийчүүдийг сэнхрүүлэв (С:5); Тойрогтоо 3 тэрбум төгрөг хаясан нь хэнтийчүүдийн талархлыг хүлээж байна (С:12); Сөрөг: Мөрөн сумын ИТХ-ын төлөөлөгчид эрхэм гишүүнтэй уулзах гээд машид чармайсан боловч Арвин хатагтай тэднийг тоож очиж уулзсангүй... Яагаад уулзаагүйг нь тодруулахад: «Миний төлөө саналаа өгөөгүй хүмүүстэй уулзах хэрэг байхгүй» гэж тэнэгтжээ (НМ:23); Монголын нэг муу барилгачин хүүхэн (НМ:23); Эрхэм гишүүн Арвин их л сонин хүн бололтой (НМ:23).
9	Н.Болормаа Сөрөг: ...Хамаатныхаа хөгшнийг даапаалж стрессээ тйалдаг зуршилтай (МН2001:40); Төрийн хүнд хэцүү албанд нухлуулж яваа бүсгүй амьтан (МН2001:40); УИХ-д тохиолдлоор сонгогдсон (МН:22); Ирэх он жилүүдийг гал зуухныхаа өрөөнд өнгөрөөхийг хүсэхгүй байгаа (МН:22); Хошин урлагийн од Туяагаас бие галбир, царай зүсээрээ... ялгардаггүй (С:9); Секс-символ (С:12); Саарал ордны «секс» билэгдэл (С:12); Цаасан малгайд дуртай (С:12); Дэн дун явна (С:20); Эмэгтэй хүний мяндсан ухаан гаргасан (С:20); Гудамжны самбарт хадсан зургаа ойр ойрхон сольж, тэр хэрээр хувцас нь нимгэрсээр, ажил хэрэгч эмэгтэйн дүр нь дэгжин хээнцэр бүсгүй болсон (С:20); Сонгуульд ялагдаад гомдолтойёо мэгшсээр намынхаа байранд ирэхийг харсан хүн бүхний зүрх шимширч байлаа (С:20).

10	Б.Дэлгэрмаа Зөрөг: Эмэгтэйчүүд улс төрд хүч үзэхийг манлайлагсадын нэг (МН:15); Жүжгийн зохиол бичсэн... хүүхдийн баяраар үлгэр зохиож бяцхан үрсэд бэлэглэсэн нь аргагүй л авьяас удам дагадгийг гэрчилжээ (МН:15). Сөрөг: УИХ-д нэр дэвших гээд 10 саяыг олох гэж яггүй зүдэрч яваа (С:13). Дөрвөн жил амьд эсэх нь мэдэгдэхгүй нам жим байсан (МН:13); Аавынхаа талаас хятад цустай гэж яригддаг түүнийг сонгогчид наймаа хийж яваа хятад авгайтай андуурсан бөгөөд нас ахих тусам хятад хүүхнүүдтэй ихээхэн адилхан харагдах болсон гэдэг (МН:13); М.Энхсайхан даргад жийгдсэн (С:26); Таваг хоолноос болж ҮЗХ-ны гишүүдтэй зодолдох шахсан (С:26).
11	Х.Хулан Сөрөг: Хашбатын охин (МН:2); Эвслийн удирдлагын заавраар СЕХ-нд гомдол гаргасан (МН:18); Шүүх сэргийлэх, зарга заальхай болж УИХ-д нэр дэвших бүртгүүлсэн (С:21); Түүний сурталчилгааны штаб асар их хэрүүл уруултай байсан (С:21); «ИЗН»-ын урвагчаар тодроод удаж буй улс төрч (МН:2); Сүүлийн үед их л оодорсон (НМ:17); Эрхээ аятайхан эдэлчихэж чадахгүй FM-ээр элдвийн юм ... чалчсан (НМ:17); Увайгүй ааш авир гаргаж байгаа (НМ:17); Шударга өрсөлдөж чадахгүй (НМ:17); Монголын сэтгүүл зүйг жорлон гэж хараах, халаглахын зөвсарт байгаа (МН:2).
12	О.Цолмон Зөрөг: Завханы 10 жилийн 1-р сургуулийн хамт олныг унах машин, тоглох хөгжим, дуулах караоке, үзэх телевизор, нийт 10-аад сая төгрөгийн зүйл бэлэглэсэн явдалд бүгд урамшиж, хичээл номондоо улам шамдан суралцах болсон; Тэрээр номонд үнэнхүү дуртай (МНӨ:14); «Бурхан багшийн сургаал» номыг Цагаан сараар хүмүүст бэлэглэсэн нь их л билэг дэмбэрэлтэй, сэтгэлийн бэлэг гэж авсан хүмүүс билэгшээжээ (МНӨ:14); Боловсролтой, түүх соёлоо мэддэг хүний бэлэг нь хүртэл өөр байдгийг хатагтай О.Цолмон харуулжээ (МНӨ:14); Японы нэртэй улс төр судлаач Пема түүнийг өөртөө итгэлтэй, өндөр боловсролтой, ухаалаг эмэгтэй гэж үнэлсэн (С:9); Эх орныхоо нэрийн хуудас болж гадныхны анхаарал, хүндэтгэлийг хүлээж байдаг (С:9); Энэтхэгт хэвлэл мэдээллийнхний анхаарлын төвд байсаар иржээ (С:9). Түүний тухай дэлгэрэнгүй сурвалжлагууд Энэтхэгийн гол том хэвлэл «Hindustan Times», «The Hindu» зэрэг сонинуудад нийтлэгджээ (С:9); Тэрчлэн эдгээр сонины Дэлхийн томоохон улс төрч, төрийн зүтгэлтэн, нэрт эрдэмтдийн хэлсэн үгнээс ишлэл авдаг нэр хүнд бүхий буланд хатагтай Цолмонгийн хэлсэн үгийг хамгийн эхэнд нь нийтэлсэн (С:9); Манай ерөнхий сайд Н.Энхбаярын Олон Улсын нэр хүнд өсөхийн хажуугаар түүний гэргий О.Цолмонг гадныхан анхаарч, хүндэтгэлтэй хандах болсон (С:9); Хатагтай О.Цолмонгийн Японы түүх соёлын талаарх арвин мэдлэг Японы хатан хаанд гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн (С:9); Энэтхэгийн энхтайвны хөдөлгөөний нэртэй зүтгэлтэн Ананд Гопалд О.Цолмонгийн Энэтхэгийн гол гол том сонинуудад өгсөн ярилцлагууд нь ихээхэн гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн учир тэрээр О.Цолмонд захидал бичсэн. Гопал урьд нь Ж.Картер, Ф.Миттеран, Н.Мандела, К.Аннан зэрэг дэлхийн нэрт хүмүүст захидал бичиж байжээ (С:10); Манай Ерөнхий сайдын олон улсын нэр хүнд өсөхийн хажуугаар түүний гэргий хатагтай О.Цолмонгийн нэр хүнд давхар өсч байна (С:10).
13	Б.Долгор Сөрөг: Эрэгтэй гишүүд түүний биеийн галбурт бүгд онц үнэлгээ өгсөн бөгөөд бие нь аргагүй мисс, даанч... хэмээн халаглацгаажээ. (ДХ2001:41);

	«Сити такси»-ны босс А.Сүхбаатарт «мөргүүлсэн» (тойргоо булаалгасан) (МН:3, 13, 19, С:4); Нөхрөө орос хүүхэнд алдаад гутарч явсан (МН:19); Дүрдээ итгэсэн үү яасан юутай ч намынхаа байрнаас салахаа байжээ (МН:19); Экс УИХ-ын гишүүд дотроос сайд болно гэж хамгийн их горьдож байсан хүн (МН:25); Түүний нэрийг ХЗДХ-ийн сайдад дэвшүүлсэн болоод л унагачихсан. Гэвч мань хүн хашралгүй ахиад аль нэг яамны дэд сайдад санаархсан нь бас л талаар болжээ (МН:25); Үүндээ ихэд гутарч, хэнгэнзтэл үйлсэн (МН:25).
14	С.Оюун Төв: «Эх орон-Ардчилал» эвсэл сонгуульд ялбал (ялна гэх магадлал тун бага байгаа.сүрв.) Гадаад хэргийн хоёр дахь эмэгтэй сайдаар С.Оюун тодрох нь (МН:8); Сөрөг: Оюун гишүүний хүүхдийн эцэг хэн болох тухай таавар саарал ордонд өрнөхөд үс нь халзарч, нүд нь цэлхийж амжаагүй залуухан гишүүд, туслахууд бие биеэсээ далдуур бүгд л «Минийх, минийх» хэмээн хөл хөөрцөг болжээ (С2003:16); Энхсайхан, Эрдэнэбат хоёр ИЗ-БНН буюу Оюунд 5-хан суудал хялайлгав (С:6); Эвсэлийн гэрээний дүрмийг л С.Оюун өчиггүй хүлээн зөвшөөрч эвсэлд нэгдсэн (С:6); Оюун дарга яагаад ... шалдаа буух болов (С:6); ИЗ-БНН-ын нөхөд «10 суудал өгье гээд байхад нь очоогүй байж сонгууль тулахаар Оюун дарга хар толгойгоо хамгаалахын тулд 5-хан суудлаар намаа худалдлаа» хэмээн хашгирч яваа (С:6); Эвслийг байгуулахдаа Б.Эрдэнэбат, М.Энхсайхан нарт бууж өгөхдөө эвслийн эрх барих дээд байгууллагад ИЗН ямар ч үүрэг рольгүй байх болно гэсэн хоёр даргын далд санааг хүлээн зөвшөөрчээ (С:13); Дөнгөж гурван суудал «зулгааж» хоцорсон (С:14); Доголон нулимстай мэдэгдэл хийж (С:14); Хөөрхий С.Оюун дарга «Хадамд хавчуулагдсан халиуны зулзага» гэгч болж (С:14); Үнэн хэрэгтээ С.Зориг агсны фракцийнхны шахалтаар л 17-р тойрогт С.Оюуны нэрийг дэвшүүлсэн болохоос бус эвслийн нөхөд түүнд сайндаа дэвшүүлээгүй аж (НМ:9); С.Оюун ... нийгмийг эмзэглүүлж байгаа асуудлуудыг далимдуулан МАХН-улс орныг удирдах үүрэг хүлээж байгаа одоогийн төр засагт үл итгэх үзэл санааг олон түмэнд төрүүлэх гэсэн атгааг санаа агуулсан нь ойлгомжтой (НМ:14); УИХ-ын гишүүн С.Оюун сонгогчдоосоо зугтаж Сонгинохайрханыг барааджээ (НМ:16); Шинэ сонгогчидтойгоо танилцах гэж нэлээд ядарч, бас сандарч яваа бололтой (НМ:19); Талийгаач ахынхаа тойрогт нэр дэвшиж, үйл хэргийг нь үнэнчээр үргэлжлүүлнэ хэмээн сонгиносоор байгаад УИХ-д сууж чадсан (НМ:16); Энэ бүсгүй гоморхол, тунирхлын ачаар дэнжигнээд л явах юм даа (НМ:16); С.Оюун тийм ч их гавьяа байгуулсан хүн биш л дээ (НМ:16); Анхынхаа нэрээр өдий зэрэгтэй яваа бөгөөд харамсалтай нь тэрбээр сайн ахынхаа үйл хэргийг үргэлжлүүлж чадахгүй байна (НМ:19); «Эх орон-Ардчилал» эвсэл ИЗН-ын тэргүүн С.Оюунд анхнаасаа л хайнга тоомжиргүй хандаж ирсэн (НМ:19); М.Энхсайхан ... С.Оюунд одон гардуулсан хэдий ч ямар нэгэн албан тушаал амласангүй. Ингэснээр С.Оюуныг үл хүндэтгэсэн байдлаа дахин илэрхийлэв (НМ:19); 2003 онд толгой нь эргэж, буруу замаар жаахан будилж явсан (НМ:22);

Одоо С.Оюун дахиж дөрвөн өрөө байр мэтэд хууриаж, нөхрийнхөө үгэнд орохгүй биз (МН:22);

Мөн тэр «Алтангадас» ассоциацийнхны тоглоом болохгүй биз ээ (МН:22);

Тэр Монголд жинхэнэ шударга ёсыг тогтоож, дайчин зоригтой тэмцэж, үндэсний бахархал болж чадавал дөрвөн өрөө байр байтугай олноо биз (МН:22);

ИЗН-аас УИХ-д сууж буй экс дарга С.Оюун хийгээд Ц.Ганхуяг мэтийн нөхдүүд (МН:1);

С.Отгонбаяр УИХ-ын гишүүн С.Оюуныг далан таваар буулгаж авлаа (МН:2);

Бэр эгч Б.Булгантай толгой дохин мэндлээгүй (МН:6);

...С.Зориг алагдсан нь ар гэр, ард түмэнд нь хүнд цохилт, уй гашуйг авч ирсэн ч зарим нэгэн хүнд «буян» болсон... талийгаачийн «буян»-ыг хүртэж яваа хүмүүсийн нэг бол яах аргагүй төрсөн дүү С.Оюун (МН:9);

Тэрээр хаа нэг тойрогтоо очихдоо хүчирхийллийн эсрэг ажил хийх хэрэгтэй гэж ахыгаа алагдсаныг сануулж сонгогчдынхоо сэтгэлийг хямруулдаг бөгөөд гадаадаас баахан эзэл, тусламж оруулж ирээд Дорнодыг тэнгэрт тултал нь хөгжүүлнэ гэсэн жижүүрийн хэдэн үгтэй гэнэ (МН:9);

Үнэн хэрэгтээ өнгөрсөн хугацаанд тэрээр тойргийнхоо сонгогчдод хоёр чингэлэг комиссын хувцас л тарааж өгсөн нь харин маргашгүй үнэн (МН:9);

За тэгээд С.Оюун бол улс төрийн үзэл бодол, төлөвшилийн талаар бүр тавиад туучихсан нэгэн (МН:9);

Чигч шударга улс төрч эмэгтэйн дүрийг та лав олж харахгүй (МН:9);

Алуурчин илэрчихвэл ахынхаа нэрээр явдаг түүний карьер дуусах магадлалтай (МН:9);

Тэгэхлээр албан тушаал, нэр төрд хэтэрхий шимтэх болсон энэ бүсгүй арай алуурчинг илрүүлэхийг хүсэхгүй байгаа юм биш биз (МН:9);

Намдаа яажуухан ганц хоёр суудал авчих вэ гэхээс найр нь хүрэхгүй шаналж явна (МН:10);

Сүүлнээс өөр ташуургүй, сүүдрээс өөр нөхөргүй үлдсэн (МН:10);

Ахынхаа нэрээр нам байгуулан шоудсан (МН:12);

Хааяа хааяахан «алуурчинг олоод аль» хэмээн итгэлгүйхэн дуугарахаас өөр гавьтай зүйл хийгээгүй (МН:12);

С.Оюун хатагтай харин хэд хэдэн эхнэр элээж амжсан Ча.Энхбаяр гэгч эртэй холбогдон үрийн зулай үнэрлэсэн (МН:12);

Нөхөрт гараад яагаад ч юм тэрээр нэг л тогтворгүй болсон төдийгүй, элдэв хор найруулалтын чанартай зүйлд нэр нь холбогдох болсон юм (МН:12);

С.Оюун тойрогтоо очихоосоо яагаад ч юм айх болсон (МН:12);

Ахыг нь хайрладаг сонгогчиддоо үйлдсэн буян нь гэвэл дөрвөн чингэлэг орчим комиссын хувцас л гэдэг (МН:12);

Хамгийн сүүлд Ц.Элбэгдоржийг дагаж тойрогтоо очихдоо хав хар дэвсгэр дээр ахынхаа зургийг байрлуулсан плакат тарааж олныг хирдхийлгэсэн (МН:12);

Нэг үнэлмээр зүйл нь өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд 17-р тойрогт дахин сонгогдохгүй гэдгээ мэдэрсэн явдал юм (МН:12);

Эвсэл байгуулахад нь түүнд багтахаар улайран зүтгэж, бас татгалзаад ч байгаа юм шиг олон зан гаргах болсон (МН:12);

Хэрэвээ сонгуульд ялдаг юм аа гэхэд гадаад хэргийн сайд болно гэсэн утопи (биелэшгүй) мөрөөдлөөр сэтгэлээ зогоон явж байсан (МН:12);

М.Энхсайхан, Б.Эрдэнэбат нар өөрийг нь илтээр элэг барин амласан таваа биш дөнгөж гуравхан тойрог үлдээсэн нь үүлгүй тэнгэрээс аянга ниргэхтэй л адил зүйл болжээ (МН:12);

Лу.Болд ... Ху намын дэмжлэгтэйгээр газрын наймаа хийн хэдэн тэрбум төгрөг цохиход нь С.Оюун зуучилсан гэдэг (МН:12);

Авилгал, хээл хахуулийг яснаасаа «үзэн яддаг» С.Оюун (өөрөө л тэгж хэлдэг болохоос...) намынхаа эгэл жирийн нөхдийг нэр дэвшүүлэлгүй хэтэвч зузаантай хүмүүст тал засах болсон (МН:12);

Түүнийг «Фортуна» Батбаяраас дөрвөн өрөө байр авсан, төдөн сая төгрөг тэндээс олсон ч гэх шиг үнэн худал нь мэдэгдэхгүй олон яриа гарах болсон (МН:12);

Түүний няхор Ч.Энхбаярыг мөнгөнд сонирхолтой төдийгүй, С.Оюуныг гартаа атгачихаад утсан хүүхэлдэй шиг л дураараа хөдөлгөх болсон тухай яриа ч тархсан (МН:12);

Юутай ч тэрээр энэ удаа бас л ахыгаа худалдах нь (МН:12);

С.Оюун битгий хэл ачулуудыг «хядаж» байгаа Б.Эрдэнэбат, М.Энхсайхан хоёр түүний шантаажийг нохой хуцсаны дайтайд бодохгүй байв (МН:12);

С.Оюун ... дөрвөн жилийн хугацаанд гавьтай зүйл хийж амжаагүй Н.Болормааг өрсөлдөгчөө болгон сонгосон (МН:12);

С.Оюуны хийсэн бүтээснийх нь хувьд биш ч ямар ч тохиолдолд ашигтай наймааны хувилбар гаргаж чадаж байгааг нь үнэлэхээс өөр аргагүй (МН:12);

Энэ бол С.Оюуны толгойноос гарахаар ч зүйл биш байж болохоор юм. Цаана нь ямар нэгэн зөвлөх байж болох ч талтай (МН:12);

Ширхэг бохь ч зарж үзээгүй тэрээр сонгуулийн сурталчилгаанд гарах мөнгөндөө нэг их санаа зовохгүй байгаа нь сонирхолтой (МН:12);

Харин Зориг ахынхаа тойргийг Зоригтод хэдэн саяар тавьж өгсөн болов уу? (МН:12);

С.Оюун ахынхаа үйл хэргийг үргэлжлүүлж, авилгал хээл хахуулийг устгана гэсээр УИХ-ын гишүүн болсон (МН:14);

Тэрээр хуучин 17-р тойрогтоо өнгөрсөн дөрвөн жилд бараг үзэгдээгүйгээр үл барам, хаа нэгтээ очихдоо гадаадын элчин сайдуудыг дагаад давхичихдаг (МН:14);

Сонгогдохгүй гэдгээ мэдрээд тойргоо «Бодь интернэшнл» компанийн захирал М.Зоригтод зарсан (МН:14);

Сүүлийн үед гадуур тархаж буй цуу яриаг анзаарахад, намынхнаасаа нүүр буруулан эрх баригч намынхантай сүжрэх болсон тухай яригдаад байгаа (МН:14);

Сүүлийн жилүүдэд түүний толгойг нэгэнт захирах болсон нөхөр Ч.Энхбаяр нь хуучин тойрогтоо нэгэнт ялах шансгүй болсон учраас Лу.Болдтой наймаалцахыг зөвлөсөн гэж энэхүү мэдээллийг өгсөн эх сурвалж нотолж байгаа юм (МН:14);

М.Зоригт сонгуулийн өмнөхөн С.Оюунд 50 сая төгрөг амласнаар 17-р тойрогт нэр дэвших эрх олж (МН:14);

Одоо тэр нэгэнт сурталчигаагаа эхлэн 50 саядаа гар дүрж эхэлсэн байх (МН:14);

Гэвч тэрээр эмэгтэй хүний нягт нарийн зангаар сурталчилгаандаа төдийлөн их мөнгө хаяхгүй (МН:14);

Ахынхаа үйлсийг үргэлжлүүлнэ гэж анхлан гарч ирсэн 17-р тойргоо баячуудад худалдсан гэгдэж буй (МН:16);

С.Оюун сонгуулийнхаа сурталчилгааг тун ч өвөрмөцөөр явуулж байна. Үнэн хэрэгтээ эхэндээ ихээхэн идэвхитэй зүтгэж байсан авч хөөрхий балчир үр нь нарны хордлого авсанаар ийн тасалдуулахад хүргэжээ (МН:16);

Тэрээр нөхрийнхөө хамтаар хүүгээ эмнэлэгт сахиж байгаа авч энэ талаараа сонгогчиддоо сонордуулах зааврыг штабынхандаа өгчээ (МН:16);

Тааралдсан сонгогч бүрт «С.Оюун гишүүний хүүхэд нь үхэх сэхэх дээрээ тулаад байна. Ингэж л зовж явна даа» хэмээн ухуулж байгаа нь «Хэрэв та С.Оюуныг сонгохгүй юм бол хөөрхий хүү нь...» гэсэн тэй агаар нэгэн сонсогдож байгаа учраас хүмүүс ихээхэн дуйргүйцэж байгаа аж (МН:16);

Уул нь монгол хүн, эх хүнд үр нь илүү чухал байх ёстой биш үү?

С.Оюун ч нэг л боломгүй зүйлүүдээр «рекламдах» дуртай сонин хүн юм аа даа (МН:16).

Жич: эх дээрх үг үсгийн алдааг жишээн дээр хэвээр үлдээсэн болно. Ишлэлийг налуу үсгээр өгсөн болно.